| Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/ | | |
|---|---|---|
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | | |
| | | |
| *Тайлагнах хугацаа* | | 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | | Компанийн нэр: **Айтүүлс ХК**<br>УБГД: 9010001141<br>Үнэт цаасны код: 543<br>Утас: 75755585<br>Имэйл: info@itools.mn, secretary@itools.mn<br>Фэйсбүүк: Айтүүлс ХК |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | | Мэдээллийн технологи, харилцаа холбоо /Дата төвийн үйлчилгээ/ |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | | Сэрэлт дөл аудит ХХК |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | | 34,452,124 |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | | Нягтлан бодогч: Б.Өнөрбадрах<br>Борлуулалтын мэргэжилтэн: Д.Жигжид<br>ТУЗ-ийн н/б дарга: Г.Янжинлхам<br>Гүйцэтгэх захирал: Ч.Мөнхжаргал |
| *1.* | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Нэгдүгээр хавсралтаар хүргүүлэв. |
| | *Орлогын тайлан* | |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | |

| | | |
|---|---|---|
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | |
| 1.1. | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | |
| | Аудитын дүгнэлтийг хавсаргав. | |
| 1.2. | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* | |
| | Аудитын дүгнэлтийг хавсаргав. | |
| 2. | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| 2.1. | *Үйл ажиллагааны Үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | Цэвэр ашгийн хувь 6%<br>Өөрийн хөрөнгийн өгөөж 6.13%<br>Нийт хөрөнгийн өгөөж 4.61%<br>Нэгж хувьцаанд ногдох ашиг 6.93 |
| 2.2. | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | Эргэлтийн харьцаа 5.62<br>Түргэн хөрвөх чадварын харьцаа 4.99 |
| 2.3. | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | **2023 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД**<br>✓ Айтүүлс ХК нь "Нээлттэй Ирээдүй – Дижитал Дархан 2023" арга хэмжээнд хамтран зохион байгуулагчаар оролцлоо.<br>✓ Айтүүлс ХК IPv6 амжилттай нэвтрүүлж эхэллээ.<br>✓ Айтүүлс ХК ISO/IEC 27001:2013 олон улсын стандартын гэрчилгээгээ гардан авлаа.<br>✓ ИЛҮҮ ХУРДАН, ИЛҮҮ ХЯЛБАР-р веб сайтаа удирдах боломЫж бүхий WordPress хостинг үйлчилгээг нэвтрүүллээ.<br>✓ TECH IS UNLIMITED уриатайгаар "ICT EXPO 2023"-д амжилттай оролцлоо.<br>✓ Веб байршуулах үйлчилгээг SSD storage-тэй болгон шинэчилж эхэллээ.<br>✓ ISO/IEC 27001:2022 МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН менежментийн тогтолцооны олон улсын "Тэргүүлэх аудитор"-н гэрчилгээгээ гардан авлаа |

| | | |
|---|---|---|
| | | |
| *2.4.* | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. |
| *2.5.* | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;* | Тайлант хугацаанд шинээр зээл аваагүй болно. |
| *3.* | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл* | |
| | Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгээгүй болно. | |
| *4.* | *Цалин урамшууллын мэдээлэл* | |
| | ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд 2022 оны ХЭЭХ-аар баталсан төсвийн дагуу цалин урамшуулал олгосон | |
| *5.* | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* | |
| | Компани нь ХЭЭХ-ыг 4-р сарын 15-ны өдөр танхимаар амжилттай зохион байгуулж, хурлын тайлан материалыг СЗХ болон МХБ-д хүргүүлсэн. Тус хурлаар ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэй сонгосон бөгөөд ТУЗ нь дарга болон Хороодын гишүүдийн хуваарилалтыг хийсэн.<br>**Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, хороод:**<br>1. ТУЗ-ийн дарга Г.Хатанболд<br>ТУЗ-ийн ердийн гишүүн А. Баттамир<br>ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Амгаланбаатар<br>ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Улаанхүү<br>ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Даваа<br>ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Тамир<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Гантуяа<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Жавхлан<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Саранчимэг<br><br>2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо:<br>Дарга – Н.Жавхлан<br>Гишүүд – З.Саранчимэг, Б.Амгаланбаатар<br><br>3. ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо<br>Дарга – Д.Даваа<br>Гишүүд – З.Саранчимэг, Г.Гантуяа<br><br>4. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо<br>Дарга – Г.Хатанболд<br>Гишүүд – Г.Гантуяа, Н.Жавхлан | |

| | |
|---|---|
| | 5. <u>ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга</u><br>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Жаргалыг 6-р сарын 2-ны өдрөөс шинээр томилсон.<br>Ч.Жаргал нь Компанийн засаглалын сургалтад сууж, гэрчилгээ авсан, компанийн засаглалын чиглэлээр ажлын туршлагатай болно. |
| *6.* | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* |
| | байхгүй |
| *7.* | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* |
| | Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөлт ороогүй болно.<br>2024 оны 3 сарын 29-ны өдрийн байдлаар нийт 2233 хүн Айтүүлс ХК-ийн хувьцаа эзэмшиж байна. Үүнээс дараах нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нар байна. Үүнд:<br>1. Ай Си Ти групп ХК – 40.2<br>2. Стандарт инвестмент ҮЦК ХХК – 10.3<br>3. AFC Umbrella FUND-AFC Asia Frontier – 13.4 |
| *8.* | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* |
| | 2023 онд татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй. |
| *9.* | *Ногдол ашгийн мэдээлэл* |
| | "Айтүүлс" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №24/004 тоот тогтоолоор компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 43 /дөчин гурав/ хувь буюу 103,356,372 төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн байна.<br>Нэгж хувьцаа тус бүрд 3 /гурван төгрөг/ төгрөгөөр тооцож ногдол ашгийг хуваарилна. |
| *10.* | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

| | |
|---|---|
| Овог, нэр: Ч.Мөнхжаргал<br>Албан тушаал: "Айтүүлс" ХК-ийн Гүйцэтгэх захирал<br>Гарын үсэг: ..........................................<br>(Тамга/тэмдэг) | Овог, нэр: Д.Алтанцэцэг<br>Албан тушаал: "Сэрэлт дөл аудит" ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал<br>Гарын үсэг: ..........................................<br>(Тамга/тэмдэг) |

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2024 оны 4 сарын 30-ны өдөр

Овог, нэр: Г.Янжинлхам

Албан тушаал: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ..........................................

СЭРЭЛТ
ДОЛ АУДИТ ХХК

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2023 02. 03 № СТА/23-04

танай ____________ -ны № ____________ -т

"АЙТҮҮЛС" ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид "АЙТҮҮЛС" ХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-д нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ын дүрэм" гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 11-40 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж

**Санхүүгийн тайланд Удирдлага, Засаглах удирдлагын хүлээх хариуцлага (үргэлжлэл)**
өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлант бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүсэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайлант бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгөхгүй юм.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхааралаа хандуулах болно.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь Шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- ✓ Санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компанид хамаарах аж

ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мөрдсөн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлын талаар ярилцсан.

***Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан***

Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор зохих байгууллагаас гаргасан хууль, дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

***Тайлангийн хэрэглээ***

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасны дагуу "АЙТҮҮЛС" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**СЭРЭЛТ ДОЛ АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

СЭРЭЛТ ДОЛ АУДИТ ХХК

**Д.АЛТАНЦЭЦЭГ**
Захирал, ММНБ

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2023 оны ... сарын ...

**"АЙТҮҮЛС" ХК-ийн товч мэдээлэл:**

| | |
|---|---|
| **Албан ёсны хаяг:** | Монгол Улс, Улаанбаатар хот<br>Баянгол дүүрэг, 2 дугаар хороо,<br>2-р хороолол 34,2 тоот байранд |
| **Хувьцаа эзэмшигчид:** | Ай Си Ти Групп ХХК<br>Стандарт Инвестмент ҮЦК ХХК<br>AFC Umbrella FUND-AFC Asia Frontier |
| **Харилцагч банкууд:** | Худалдаа хөгжлийн банк<br>Хас банк<br>Хаан банк<br>Төрийн банк |
| **Аудитын компани:** | **Сэрэлт Дөл Аудит ХХК** |
| **Үйл ажиллагааны зөвшөөрөл:** | Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааны **23-2015** дугаарын тусгай зөвшөөрөлтэй бөгөөд 2024 оны 12-р сар хүртэл сунгуулсан. |
| **Албан ёсны хаяг:** | УБ хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Сүхбаатарын гудамж, Peace building . 302 тоот |

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Тодруулга | 2022.12.31 | Аудитлагдсан 2023.12.31 |
|---|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 5 | 483,470,086.9 | 340,709,085.9 |
| Дансны авлага | 6 | 693,607,167.5 | 1,183,910,966.6 |
| Татвар НДШ-ийн авлага | | 99,000.0 | |
| Бусад авлага | 6 | 17,974,819.7 | 36,416,788.5 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | | |
| Бараа материал | 7 | 145,830,198.6 | 144,635,563.5 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 8 | 36,021,183.4 | 11,413,723.3 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **1,377,002,456.0** | **1,717,086,127.8** |
| Үндсэн хөрөнгө | 9 | 3,560,937,332.5 | 3,492,122,514.8 |
| Биет бус хөрөнгө | 10 | 27,277,776.6 | 26,148,367.0 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | | 70,446,145.0 | 80,446,145.0 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **3,658,661,254.1** | **3,598,717,026.8** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | | **5,035,663,710.1** | **5,315,803,154.7** |
| Дансны өглөг | 11 | 52,891,498.1 | 128,592,870.5 |
| Цалингийн өглөг | | 262,742.9 | |
| Татварын өр | 12 | 174,642,594.8 | 62,778,997.9 |
| НДШ-ийн өглөг | | | |
| Урьдчилж орсон орлого | | 36,428,820.0 | 114,334,875.2 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **264,225,655.8** | **305,706,743.6** |
| Урт хугацаат зээл | | 997,000,000.0 | 997,000,000.0 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | **997,000,000.0** | **997,000,000.0** |
| **Нийт өр төлбөрийн дүн** | | **1,261,225,655.8** | **1,302,706,743.6** |
| Хувийн өмч | 13 | 1,481,441,363.3 | 1,481,441,363.3 |
| Нэмж төлөгдсөн капитал | | 763,114,860.0 | 763,114,860.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | 460,721,652.2 | 460,721,652.2 |
| Хуримтлагдсан ашиг | | 1,069,160,178.9 | 1,307,818,535.6 |
| **Эздийн өмчийн дүн** | | **3,774,438,054.3** | **4,013,096,411.1** |
| **ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН** | | **5,035,663,710.1** | **5,315,803,154.7** |

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Тодруулга | 2022.12.31 | Аудитлагдсан 2023.12.31 |
|---|---|---|---|
| **Борлуулалтын орлого (цэвэр)** | 14 | **3,877,499,813.7** | **3,904,083,856.4** |
| Борлуулалтын өртөг | 15 | 2,303,172,617.2 | 2,803,346,511.1 |
| **Нийт ашиг /алдагдал/** | | **1,574,327,196.5** | **1,100,737,345.3** |
| Түрээсийн орлого | | 52,181,818.2 | 35,545,454.6 |
| Хүүний орлого | | | 2,335,935.8 |
| Ногдол ашгийн орлого | | | |
| Бусад орлого | | | 24,245.0 |
| Борлуулалт, маркетингийн зардал | 16 | | 203,683,303.7 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | | 1,331,037,631.9 | 420,481,664.3 |
| Санхүүгийн зардал | | | 239,280,000.0 |
| Бусад зардал | 17 | 2,843,608.0 | 12,090,558.7 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | 4,122,835.3 | 2,730,553.1 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | 4,177,117.9 | 681,340.2 |
| Бусад ашиг (алдагдал) | | | |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | | **300,927,727.9** | **266,519,347.3** |
| Орлогын татварын зардал | 18 | 30,377,133.6 | 27,860,990.6 |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | | **270,550,594.3** | **238,658,356.7** |
| **Орлогын нийт дүн** | | **270,550,594.3** | **238,658,356.7** |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал ) | | | |

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлсөн капитал | Хөрөнгийн дахин | Хуримтлагдсан ашиг | Дүн |
|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **1,481,441,363.3** | **763,114,860.00** | **460,721,652.2** | **798,609,584.6** | **3,503,887,460.1** |
| Залруулсан үлдэгдэл | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал | | | | 270,550,594.3 | 270,550,594.3 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | |
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **1,481,441,363.3** | **763,114,860.00** | **460,721,652.2** | **1,069,160,178.9** | **3,774,438,054.3** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг, (алдагдал) | | | | 238,658,356.7 | 238,658,356.7 |
| **2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **1,481,441,363.3** | **763,114,860.00** | **460,721,652.2** | **1,307,818,535.6** | **4,013,096,411.1** |

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | 2022.12.31 | Аудитлагдсан 2023.12.31 |
|---|---|---|
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **3,706,940,180.5** | **3,702,915,006.6** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 3,084,784,580.5 | 3,677,188,337.1 |
| Буцаан авсан албан татвар | | |
| Бусад мөнгөн орлого | 622,155,600.0 | 25,726,669.5 |
| **Мөнгөн зарлагын дүн (-)** | **3,223,354,009.1** | **3,345,156,633.6** |
| Ажиллагчдад төлсөн | 412,442,542.7 | 565,534,702.9 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 118,710,057.7 | 164,846,814.5 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 2,063,290,123.0 | 1,769,774,261.3 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 134,792,143.8 | 186,578,433.3 |
| Түлш, шатахуун, сэлбэг | 8,448,045.5 | 5,446,594.6 |
| Хүүний төлбөрт төлсөн | 191,280,000.0 | 64,476,000.0 |
| Татварын байгууллагад төлсөн | 100,942,926.6 | 475,940,471.0 |
| Даатгалын төлбөрт төлсөн | | 3,321,860.6 |
| Бусад мөнгөн зарлага | 193,448,169.9 | 109,237,495.4 |
| **ҮҮАжиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний** | **483,586,171.4** | **357,758,372.9** |
| **Мөнгөн орлогын дүн** | **625,130,072.9** | **136,296,747.9** |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаалт | 604,810,072.9 | 133,550,832.1 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 20,320,000.0 | 300,000.0 |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | 110,000.0 |
| Хүлээн авсан хүүний орлого | | 2,335,915.8 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **869,982,623.4** | **639,737,835.3** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 319,433,195.5 | 324,589,035.4 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | 5,599,000.0 |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | | 10,000,000.0 |
| Бусдад олгосон зээл урьдчилгаа | 550,549,427.9 | 299,549,799.9 |
| **ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(244,852,550.5)** | **(503,441,087.4)** |
| **Мөнгөн орлогын дүн (+)** | **74,161,750.0** | |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 74,161,750.0 | |
| **Мөнгөн зарлагын дүн** | **82,099,547.9** | |
| Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 82,099,547.9 | |
| Бусад мөнгөн зарлага | | |
| **СҮАжиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **(7,937,797.9)** | |
| Валютын ханшийн зөрүү | 2,541,606.1 | 2,921,713.5 |

| | | |
|---|---|---|
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **233,337,429.0** | **(142,761,000.9)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **250,132,657.9** | **483,470,086.9** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **483,470,086.9** | **340,709,085.9** |

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.